

БНХАУ-ЫН ХИЛИЙН БОЛОН ХИЛИЙН ДЭГЛЭМИЙН ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭЖ БУЙ АСУУДЛЫГ СУДАЛСАН НЬ

Доктор, профессор Ц.Ганболд

БНХАУ-ын хилийн нийт урт нь 22143 км, үүнээс усан хил нь 14500 км бөгөөд 9,6 сая ам дөрвөлжин километр талбай бүхий нутаг дэвсгэртэй, 15 улстай хиллэдэг.

Монгол Улстай 4709,658 км буюу хуурай газрын хамгийн урт газар нутгаар хиллэж, хилийн 13 боомтоор харилцан үйл ажиллагаа явуулж, БНХАУ-ын талаас өөртөө засах Шинжаан, Ганьсу муж, Өвөрмонголын 3 орны нутаг дэвсгэрээр хиллэдэг.

Улсын хилийн боомтын асуудлаар НАХЯ-ны цагаачлалыг удирдах газар, ХАЧА-ийн хил хамгаалах хороо, ӨМӨЗО-ны хилээр орох гарах асуудал хариуцсан шалган нэвтрүүлэх ерөнхий газар, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шугамаар харилцан ажилладаг. БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс баталсан 284 хилийн боомт байдгаас 146 нь далайн эргийн, 136 нь эх газрын, 27 нь дотор газрын хилийн боомт болно.

БНХАУ-ын хил хамгаалалт, түүнийг зохион байгуулж буй байдал, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлдэг, гарсан зөрчлийг ямар арга тактикаар илрүүлж, захиргааны болон эрүүгийн ямар шийтгэл ноогдуулдаг талаар хятад эх сурвалжийг ашиглан Өвөр монголд уйгаржин монгол дээр хэвлэгдсэн “Хил хамааралтын ухаан” буюу манайхтай дүйцүүлбэл “Хилчний сурах бичиг”-тэй агуулгаараа дүйцэх албан хэрэгцээнд зориулсан номноос кириллд буулгасан, уйгаржин бичгийн болон өвөр монгол хэлний онцлогтойгоор

нь танилцуулж байна. Мөн зэргэлдээ улсын хил хамгаалах байгууллагаас хилийн төлөөлөгчийн үйл ажиллагааг хэрхэн явуулдаг талаар тусгав.

Хилийн уулзалтууд ихэвчлэн өвөр монгол орчуулагчдын тусламжтайгаар явагддаг учраас хил хамгаалалтын зарим нэг нэр томьёо, хэллэгийн учрыг олоход танин мэдэхүйн ихээхэн ач холбогдолтой гэж үзэв. Тухайлбал, Гоолдлоготой хүн - энэ бол дотоодыг хамгаалах тусгай нэр томьёо болно. Даруй өрх амын хамааралтын ажил дунд ялт ажиллагааны сэжигтэн ба нийгмийн амар түвшинг самруулсан сэжигтэй хилийн хамааралтын оронд улсаас урваж гадагш дотоод ба дайсанд бууж өгөх аюултай этгээдийг зааж байна.

Хилийн хамааралтын ухагдахуун.

Хилийн хамааралтын ухагдахууныг ойлгоход урдаар хилийн хамааралтын холбогдол бүхий үндсэн ухагдахууныг ойлгох хэрэгтэй.

Нэг. Хилийн зааг. Нэг улсын нутаг дэвсгэрийг зэргэлдээ улсын нутаг дэвсгэртэй зааглаж харъяат далай ба харъяат агаарыг хувиарлах зааг шугамаар нэг улсын нутаг дэвсгэрийн хүрээ хэмжээг тогтоосныг хилийн зааг гэнэ.

Хоёр. Хил. Хил нь даруй улсын нутаг дэвсгэрийн зах хөвөөн орон бүсийг хэлж буй хилийн заагийн дотоод талыг хамарсан зохих орныг ерөнхийлөн зааж байна.

Гурав. Хилийн дүрэм. Улсаас улсын дотоодод нийтэлсэн хуулийн холбогдол

бүхий тогтоол ба холбогдол бүхий олон улсын гэрээ ба хэлэлцээрийг үндэслэн тогтоосон хилийн заагийг хамаарах эл зүйлийн бодит арга хэмжээ дүрэм тогтоолыг ерөнхийлсэн хилийн дүрэм гэдэг.

Дөрөв. Хилийн хамааралт. Хилийн дүрмийн хамаарал бүхий тогтоолоор хилийн заагийн дотоод талын зохих оронд хамааралт явуулахыг хилийн хамааралт гэдэг.

Хилийн хамааралтын үндсэн үүрэг бол: манай улсын холбогдол бүхий хууль цааз ба төрийн бодлогыг үндэслэн хилийн орны нийгмийн орны амар түвшинг хамаарч хилийн зэвсэглэлээр сэргийлэх, дайсны тагнуул ба бусад ялт этгээдийн хилийн заагт халдах улс ба нийгмийн амар түвшинг самууруулах ажиллагааг сэргийлэх буюу цохилт өгөх, хилийн иргэний хил давах явдлыг хамаарах, хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэж улсын аюулгүй хийгээд хилийн эмх журам тогтоон барихыг хамгаална.

Хилийн хамааралтын үүрэг.

Хилийн хамааралтын үндсэн үүрэг бол улсын эрх мэдэл нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн болон улсын амар түвшинг батлан хилийн эмх журмыг хамгаална.

Түүний бодит үүрэг нь: олон түмний ажил, улсын хилийн хамгаалах, хилийн орны амыг хамгаалах, эмх журмыг хамгаалах мэдээ, сэлтийг байцаан судлах далдуур арилжаалах, хорт эд бараа наймаалахыг баривчлах, улсын хилийг хулгайгаар давсанд цохилт өгөх ба хязгаарлах, хилийн эмх журмыг зөрчсөн эл зүйлийг эрүүгийн хэргийг илрүүлэх гадаадад холбогдсон хилийн хэргийг шийдвэрлэх зэрэг байна.

Хилийн хамааралтын салаа мөчрийн эрх.

Хилийн хамааралтын салаа мөчрийн ажлын үүргийг үндэслэн доорхи хэдэн зүйлийн эрхтэй байдаг.

Нэг. Засаг захиргааны эрх. Засаг захиргааны гар дүрэх эрх. Хилийн хамааралтын салаа мөчир нь түүний дүрэм тогтоолыг хөнгөвтөр зорчсон үйл ажиллагаанд засаг захиргааны гар дүрэх эрхтэй байж үйл ажиллагаат хүнийг ятган сургах, ятган хориглох, албадан өөрчлөх эрхтэй. Бас засаг захиргааны зарлиг, мэдээлэл, зар нийтэлж хилийн хамааралтын оронд орж ирсэн ба оршин сууж байгаа хүмүүсийг улсын хууль, цааз ба хилийн хамааралтын дүрэм тогтоолыг эрхбиш журамлахыг шаардах эрхтэй байхыг зааж байна. Энэхүү засаг захиргааны гар дүрэх эрхийг зохих ятгах чанар хуулийн хязгаарлах чанар ба албадлагын чанартай. Амрыг хамгаалах засаг захиргааны хамааралтын эрх нь хилийн хамааралтын салаа мөчрөөс хилийн амрыг хамгаалах засаг захиргааны талаар хөгжүүлэх хамааралтын эрхийг зааж байна. Улсын тогтнолыг үндэслэвэл хилийн хамааралтын салаа мөчрийг хилийн орны ажил үйлдвэрлэл, гэр бүлийг данслах оршин суух, явж нэвтрэх зэрэг явдлыг хамаарах эрхтэй. Энэ бол хилийн хамааралтын салаа мөчрийн засаг захиргааны эрхийн бодит илрэл болно. Амрыг хамгаалах засаг захиргааны хамааралтыг дамжин хилийн эмх журмын түвшин тайван байхыг баталж чадна. Амрыг хамгаалах шийтгэн торгох эрх: хилийн хууль дүрмийг зөрчиж тогтоол ёсоор засаг захиргааны шийтгэл өгч болно. Хилийн

хамааралтын салаа мөчрөөс холбогдол бүхий хууль цааз ба хууль тогтоолоор шийтгэл өгөх эрхтэй. Ж-нь: хилийн оронд оршин суухын хамааралт явах нэвтрэх явдлын хамааралтын дүрмийг зөрчиж хилийн хамааралтын салаа мөчрийн ажилтны хууль ёсны эрхээ хэрэгжүүлэхийг харшлах, хамааралтыг дагахгүй хорьж ятгахыг сонсохгүй. зэрэг зүйлүүд. Амрыг хамгаалах засаг захиргааны шийтгэн торгох эрх бол хилийн хамааралтын салаа мөчрийн засаг заиргааны эрхийн чухал бүрэлдэхүүн болох бөгөөд мөн ч бусад эрх мэдлээ явуулахын бодлого мөн. Хилийн хамааралтын дүрмийг сурган хүмүүжүүлж эл зүйлийн хамааралтын ажлыг сайтар хийхэд чухал утга агуулгатай юм.

Хоёр. Эрүүгийн хэргийг хамаарах хууль

Хилийн хамааралтын салаа мөчрөөс хилийн хаших хаах ба цагдалт дунд илрүүлсэн улсын хилийг хулгайгаар давах далдуур арилжаалах, буу зэвсэг хорт эд зэрэг хилийн хамааралтыг зөрчсөн хэргийг сайн тагнаж байцаан судалж илрүүлэх эрхтэй. Хилийн орны бусад ялт хэргийг хилийн хамааралтын салаа мөчрөөс дотоодыг хамгаалах байгууллагын гол хамаарах салаа мөчиртэй хамжилцан сайн байцаах ба илрүүлэх хэрэгтэй.

Гурав. Цэргийн явдлын эрх.

Хилийн хамааралтын салаа мөчрийн цэргийн явдлын эрх бол түүний хариуцаж байгаа цэргийн явдлын үүргээс тогтоогддог. Түүний үүрэг тушаалын хэмжээнд доорхи эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Зэвсэгт хүчнээр хаших, нэхэмжлэн баривчлах

эрхтэй. Хилийн хамааралтын салаа мөчир нь үүрэг гүйцэтгэхэд хилийн амар түвшнийг эвдэх, ялт этгээдийг хаан хаших, нэхэмжлэн баривчлах эрхтэй. Зэвсэгт хүчнээр харгалзан хамгаалах эрх. Манай улсын хилд хууль бусаар орж ирсэн гадаадын хүн, зам харилцааны багаж, хэрэгслийг хилийн хилийн хамааралтын салаа мөчрөөс зэвсэгт хүчнээр харгалзан хамгаалах эрхтэй. Зэвсэгт хүчнээр өөрийгөө хамгаалах эрх. Эл зүйлийн ялт этгээдийг нэхэмжлэн баривчлах үед хил давах ба хилээс гадагш буудаж болохгүй. Хилийн үүрэг гүйцэтгэх явцад хилийн гаднах дайсан тагнуул цөөн тоогоор түрэмгийлэн орж ирсэн дайсны өдөлхийлэлт хийх, халдалт, бүгэлт хийх зэвсэгт хүчнээр хор далдуур арилжаалах бүлэглэлийн зэвсэгт эсэргүүцэл тохиолдох үес, өөрийгөө хамгаалах эрхтэй.

Дөрөв. Гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэх эрх.

Холбогдол бүхий тагнуулыг үндэслэн хилийн хамааралтын салаа мөчрөөс хилийн оронд үүссэн гадаадад холбогдсон асуудлыг шийдвэрлэх эрхтэй. Хилийн дүрэм тогтоолыг үндэслэн хилийн гаднах хилийн хамааралтын салаа мөчиртэй зөвлөлдөх буюу харилцан шийдвэрлэх хэрэгтэй.

Хоёр. Хилийн хамааралтын хууль цаазын дүрэм тогтоол. Хилийн хамааралт бол хууль хэрэгжүүлэх ажиллагаа болно. Түүний журамлах хууль, цаазын дүрмийг хилийн дүрэм тогтоол гэх буюу хилийн хамааралтын хууль – дүрэм гэдэг. Энэхүү хууль цаазын дүрэм нь дотоод дахь хууль ба дэлхий нийтийн хууль гэх хоёр хэсгээс

бүрэлддэг.

нэг. Улсын дотоод дахь хуулийн хэсэг. Хилийн эмх журмыг хамгаалахын төлөө улсаас үргэлж улсын дотоод дахь хууль тогтоох аргаар эл зүйлийн холбогдол бүхүй хилийн асуудлын, хууль цаазын дүрэм тогтоодог. Эдгээр дүрмийн доорх зүйлд хувааж болно. Улсын хууль цаазын дотор холбогдол бүхий хилийн дүрмийн тухай тогтоол, хилийн амар түвшнийг хамгаалах ба хилийн сүрсүлдийн төлөө, дэлхийдээрх олонх улс түүний үндсэн хуулиндаа бүр хилийн хамгаалж хамаарах тухай хууль цаазын зүйлийг тогтоосон буюу тусгай хуулийг тогтоодог.

Нэгдүгээр хугацааны гуравдугаар бүгд хуралдаанаас /1989 он. Ц.Г./ хойш манай улс алхам алхмаар хуулиар улсыг засах замд орж хууль дүрмийн байгуулалт тун ихээр хөгжсөн байна. Манай улсын “Эрүүгийн хууль”-ийн 318,319,320,321,322,323 дугаар зурваст тодорхой тогтоосон нь улсын хилийн хөшөө хилийн шонг эвдэх улсын хилийг хулгайгаар давах, бусад хүмүүсийг дагуулан улсын хилийг хулгайгаар давагчдыг хугацаатай хорих, түр хорих буюу захиран хамаарахын хамт зоос мөнгөөр торгож шийтгэнэ. Улсаас нийтэлсэн хилийн хамааралтын ажилтай холбогдолтой бусад хууль цааз нь жишээлбэл, “Бүгд найрамдах Думдад Ард Улсын гадаадын хүний хилээр орох гарах хамааралтын хууль”, “Бүгд найрамдах Думдад Улсын ард иргэний хилээр орж гарах хамааралтын хууль”, “Улсын харъяатын хууль”, “Боомтын хууль” хийгээд хорыг цаазлах далдуур арилжаалах хор панзлахыг ялтан сэтгэх хулгай худалчийн яллан

шийтгэх зэрэг холбогдол бүхүй тогтоол байдаг. Энэ нь манай улсын хилийн хамааралтын тухай хууль цаазыг алхам алхмаар сайжран төгөлдөржсөн байна. Улсын Засгийн ордны байгууллагаас тогтоосон засаг захиргааны хууль тогтоолд жишээлбэл, “БНДумдад Ард Улсын гадаадын онгоц сал, далайн гармаар орох гарах хамааралтын арга” Дотоодыг хамгаалах яам, Зам харилцааны яам болон тариалан мал аж ахуй загасны аж ахуйн яамнаас тогтоон нийтэлсэн “Далай дагуу орны онгоц сал, гармын амрыг хамгаалах хамааралтыг чангатгах хэдэн асуудлын тогтоол” зэрэг буй.

Засаг захиргааны тогтоолыг түшиглэн хилийн хамааралтанд хэрэгжүүлэх нь отгын хилийн хамааралтын ажлын нэг зүйлийн үндсэн хэлбэр болно. Орон нутгийн засгийн газраас тогтоосон орон нутгийн чанартай хил хамгаалалтын хууль тогтоол.

Манай улсын хил хязгаар өргөн уудам эл газрын хилийн байдал зөрөөгөөр их байдгаас болоод улсаас нэгдэлтэй хилийн хамааралтын хууль дүрмийг хараахан тогтоогоогүй. Хандлагат чанартай хамааралтыг нэн сайн явуулахын төлөө эл хилийн муж, Өөртөө засах орны ардын их хурал ба Ардын засгийн ордноос улсын холбогдол бүхий хууль цааз ба дүрэм тогтоолыг үндэслэн тус газрын бодит байдалтай уялдуулан орон нутгийн чанартай засаг захиргааны хууль дүрмийг тогтоосон байна. Ж нь: хилийн хамааралтын дүрэм, нарийн дүрэм, зар тунхаг, арга зэрэг буй. Хилийн орон нутгийн хууль дүрэм бол улсын хилийн

хамгаалалтын төрийн бодлогын бодит илрэл болно. Тэр нь тэр нь хилийн хамгаалалтын төрийн бодлогын бодит байдал мөн ч хилийн хамгаалалтын төрийн бодлогын нөхвөрлөл болно. Тэр бол манай улсын хилийн хамааралтын ажлын нэгэн их онцлог байж хилийн эмх журмыг хамгаалах ажлын дунд хүнд чухал үйлдэл үзүүлж байдаг.

Хоёр. олон улсын хуулийн хэсэг. Олон улсын хуулийн хэсгийн хилийн хамааралтын дүрэмд голдуу хөрш улсын хооронд байгуулсан хилийн дүрэмтэй холбогдол бүхий хоёр талын гэрээ хэлэлцээр зөвлөлцөл ба хилийн зорчилт олон улсын хуулийн холбогдол бүхий тогтоол зэргийг заана.

Цохилтоо чангатган хилийг хулгайгаар давах ялт ажиллагааг чангаар яллах нь.

Думдадын Эрүүгийн хуулийн 318, 321, 322 р зурваст \зүйлд\ жич ардын төлөөлөгчдийн байнгын хорооны “Улсын хилийг хулгайгаар давуулахаар бусдыг зохион байгуулж хүргэсэн ялт ажиллагааг чанга шийтгэх тухай нөхвөр тогтоол-д хилээр орж гарах хамааралтын хууль тогтоолыг зөрчих ба ашиг олох үүднээс улсын хилийг хулгайгаар давуулахаар бусдыг зохион байгуулсан ялт этгээдийг яллах.. хилийн хамааралтын хууль тогтоолын холбогдол бүхий зурваст цөм тохиромжтой тогтоолтой юм. Эдгээр нь цөм улсын хилийг хулгайгаар давах ажиллагаа зэрэгт цохилт өгч шийдвэрлэх хууль цаазын зэвсэг болно, үүрэг тушаалт салаа мөчир нарийн хянамгай хэрэгжүүлж хуулийг зөрчвөл заавал нэхэмжилж хуулийг хэрэгжүүлэхэд заавал чанга

байх. Улсын хилийг хулгайгаар давах ажиллагааг гадаадын засгийн газартай нягт хамжилцан, хамтаар сэргийлэн шийдвэрлэх нь.

Наяад оноос нааш улсын хилийг хулгайгаар давах ажиллагаа бүх улсын хэмжээгээр түргэн хөгжин дэлгэрч хүний тоог нь ч жилээс жилд нэмэгдэж, онц зарим мужаас гадна улсын хилийг хулгайгаар давах явдал цөм товойн ялгарч, улсын хилийг давж гадаадад гарсан хүмүүс дэлхийн хэдэн арван улс ба газар оронд тархжээ. Улсын хилийг хулгайгаар давах ажиллагаа өмнөөс умарш, далай дагуун орноос дотор газар орон руу хөгжиж, манай улсын нийгмийн нэгэн товойсон асуудал болж, улсын гадаадад тун муу нөлөөтэй болгож манай улсын нэр хүндийг сүрхий эвдэж, зарим улсад бас Думдад улсыг эсэргүүцэх сэтгэлгээг үүсгэсэн байна.

Намын төв хороо, Улсын явдлын хорооноос энэхүү асуудлыг туйлаар хүндэтгэн, олон удаа заавар ба байрлуулалт хийж энэхүү асуудлыг даруй түргэн шийдвэрлэхийг шаардсан байна.

Ялзран доройтохыг эсэргүүцэн дутагдлаа засварлах нь.

Улсын хилийг хулгайгаар давах зарим ажиллагаа нь газар орны зарим удирдлагын дураар нь тавих болон хуулийг хэрэгжүүлж байгаа хүмүүсийн цэгц бус ажиллагаатай холбогдолтой юм. Иймээс улсын хилийг хулгайгаар давах ажилд цохилт өгч хязгаарлах ажлын дунд эрхбиш ялзармалыг эсэргүүцэх тэмцэлтэй нягт уялдуулах шаардлагатай. Намын суртлын асуудал бол нам ба улсын мөхөж сөнөхтэй

холбогдох зангилаа асуудал болно. Иймээс эрхбиш улсын ажилтан ба хуулийг хэрэгжүүлж байгаа хүмүүс улсын хилийг хулгайгаар давах хүмүүсийг далдуур тавих буюу үл мэдэгч, дураар нь тавих зэрэг хууль дүрмийг зөрчсөн ажиллагааг нарийн хянамгай байцаан шийтгэх хэрэгтэй. Энэ бол эзэмшлийг эсэргүүцэх тэмцлийн нэгэн чухал агуулга, мөрдөөн басч улсын хилийг хулгайгаар давах ажиллагааг хориглох нэгэн чухал гогцоо болно.

Далдуур арилжаалахын агуулга хийгээд хор хөнөөл.

Нэг. Далдуур арилжаалах ухагдахуун. Энэ нь боомтын хууль тогтоолыг зөрчин хилийн боомтыг хянан хамааралтаас зайлан дутааж, улсаас хилд оруулж гаргахыг цаазлан хязгаарлах буюу хууль ёсоор боомтын гаальд тушаах ёстой бараа бодисыг зааж байна. Дээрх томъёолол нь даруй далдуур арилжаалах нь юуны өмнө боомтын хуулийг зөрчин, хилийн боомтын хянан хамааралтаас зайлан дутааж байгаа үйл ажиллагаа болно. Хилийн боомт бол улсын хилээр оруулж гаргах эл зүйлийн эд барааг хянан хамаарах байгууллага байж боомтын хуулийн гол хэрэгжүүлэгч болно.

Хилийн боомтын хянан хамааралтаас зайлан дутаах гэдэг нь хууль бусаар эд бараа тээвэрлэн хилийн боомт нээгээгүй газраар хилээр оруулж гаргах зарим нь хэдийгээр хилийн боомтоор гарч орсон ч эд бараагаа хуурмагаар мэдүүлэх, далдлан мэдүүлэх, нуун далдлах зэрэг арга хэрэглэхийг зааж байна.

Хоёрт. Далдуур арилжаалах нь улсын гадаад арилжаа худалдааны хамааралтыг зөрчсөн үйл ажиллагаа болно. Улсын гадаад арилжаа худалдааны хамааралтыг эвдэх хэрэг нь зөвшөөрөлгүй гээр өөртөө улсаас хилд оруулах гаргахыг хязгаарлаж байгаа буюу боомтын гааль тушаах хэрэгтэй эд барааг тээвэрлэн авч явж хилд оруулж гаргах үйл ажиллагааг зааж байна.

Далдуур арилжаалах үйл байдал нь хүнд, манай улсын “Эрүүгийн хууль”-ийн холбогдол бүхий хууль тогтоолыг зөрчсөн байвал, далдуур арилжаалсан ялыг бүрэлдүүлдэг.

Далдуур арилжаалсан ял хийгээд далдуур арилжаалсан үйл ажиллагаа.

Далдуур арилжааны ял.

“БНДАУлсын боомтын хууль”-ийн 47-т далдуур арилжаалах ялд доорхи мэтээр ийн тогтоожээ.

Улсын хилээр оруулж гаргахыг цаазалж байгаа хорт бодис, буу зэвсэг, хуурамч зоосыг тээвэрлэх авч явах, шуудангаар оруулж гаргах, буюу улсаас гаргахыг цаазалж байгаа түүхэн дурсгалт бодисыг тээвэрлэх, авч явах, шуудангаар явуулах хилээр гаргах, Боомтын зөвшөөрөлгүй мөрдөөн боомтын, гаалийн нөхвөрлөн тушаах, хилээр оруулахыг онц зөвшөөрсөн гаалийн үлдэгдэл бараа, гаалийн хасахаар онц тогтоосон буюу гаалийн хэлтрүүлэх огц тогтоолтой эд барааг дураараа худалдаж, тоо хэмжээ нь нилээд их байна. Зэвсэгт хүчнээр далдуур арилжаалахыг хамгаалж, далдуур арилжаалах эд барааг байцаахыг хүчирхэглэн эсэргүүцэж,

тоо хэмжээг бага гэлгүй цөмийг далдуур арилжаалсан ялд багтана.

Үүнээс гадна доорхи үйл ажиллагааг бас далдуур арилжаалсан ялд багтаан шийдвэрлэхээр тогтоожээ: Далдуур арилжаалснаас, улсаас оруулж гаргахыг цаазалж байгаа бодисыг хууль бусаар шууд худалдан авах буюу далдуур арилжаалснаас далдуур арилжаалж оруулж ирсэн бусад бараа бодисыг шуул хууль бусаар худалдан авах бөгөөд тоо хэмжээ нь нилээд их. Дотоод далай, харъяат далайд улсаас оруулж гаргахыг цаазалж байгаа бодисыг тээвэрлэх, худалдан авах, панзлах буюу улсаас оруулж гаргахыг хязгаарлаж байгаа бараа бодисыг тээвэрлэх, худалдан авах, панзалж, тоо хэмжээг нилээд их, хууль ёсны гэрчгүй.

Далдуур арилжаалахын үйл ажиллагаа.

БНДАУлсын Боомтын хуулийн Засаг захиргааны залагал (засаглал.Ц.Г.) хэрэгжүүлэх нарийн дүрэм” ийн 2-3 д Далдуур арилжаалах үйл ажиллагааг доорхи байдлаар тогтоожээ.

Төрийн явдлын хорооноос эрх олгосон байгууллагын зөвшөөрөлгүйгээр боомт байгуулаагүй газраар улсаас хилээр оруулж гаргахыг цаазалж байгаа бодис, улсаас оруулж гаргахыг хязгаарлах буюу боомтын гааль тушаах хэрэгтэй эд барааг тээвэрлэн, авч явж хилээр орж гарах,

Боомт байгуулсан газраар өнгөрч, нуун далдлах хуурмаглах, мэхлэн мэдүүлэх, хуурмагаар мэдүүлэх буюу бусад аргаар боомтын хянан хамааралтаас зайлан тогтоож, улсаас хилээр оруулж гаргахыг цаазалж байгаа бодис, улсаас оруулж гаргахыг

хязгаарлаж байгаа буюу боомтын гааль тушаах хэрэгтэй эд барааг тээвэрлэн авч явж, шуудангаар оруулж гаргах, Боомтын зөвшөөрөлгүй боомтын гаалиа нөхвөрлөн тушааж, хилээр оруулж ирсэн хилийн гаднах тээврийн хэрэгсэл зэргийг дураараа худалдах, Боомтын зөвшөөрөлгүй мөрдөөн боомтын гаалиа нөхвөрлөн тушааж, гаалийг хасахаар тусгай тогтоосон буюу гаалиас хэлтрүүлэн хэвийн тусгай тогтоосон хэрэгцээтэй эд барааг дураараа худалдах эсвэл гаалийг хасан хэлтрүүлээд тусгай тогтоосон газар оронд хэрэглэх эд барааг дураараа хил доторх бусад газар оронд тээвэрлэн хүргэх, Үүнээс гадна доорхи үйл ажиллагааг бас байдлыг үндэслэн далдуур арилжаалах үйл ажиллагаагаар шийтгэхээр тогтоожээ: Далдуур арилжаалснаас шууд далдуур арилжаалж оруулсан эд барааг хууль бусаар худалдан авах, дотоод далай, харъяат далайгаар улсаас хилээр оруулж гаргахыг хязгаарлаж байгаа эд барааг тээвэрлэх, худалдан авах, панзлах бөгөөд хууль ёсны гэрчгүй зэрэг.

Далдуур арилжаалахын хор хөнөөл.

Далдуур арилжаалах ажиллагаа нь манай улсын нийгэм журамт аж ахуйн бүтээн байгуулалт болон нийгмийн үйлдвэрлэл, амьдралын эмх дэглэмд олон талын хор хөнөөл авчран тэр нь голдуу доорх хэдэн талаар илэрч байна.

Далдуур арилжаалах ажиллагаа нь улсын гадаад арилжааны хамааралт ба оруулж гаргах бодисын хамааралтыг эвджээ. Гадаад арилжаа нь улсын хамааралтыг хүлээх бөгөөд эл улсын

хоорондох таваарын үнийг их зөрөө байгаагаас болж хууль бус этгээд хууль бусаар их ашиг хөөцөлдөж арга бүхнийг сүвэгчлэн хамааралтаас зайлан дутааж улсаас хязгаарлаж байгаа эд барааг хувиараа тээвэрлэн улсын гадаад арилжааны хамааралтыг төрийн бодлого ба хууль тогтоолыг хүнд сүрхий эвдэж нийгэм журамт аж ахуйн бүтээн байгуулалтыг эвдсэн байна. Далдуур арилжаалах ажиллагаа нь улсын их хэмжээний гааль мөнгийг талаар урсгаж, улсад тун их сүйдэл авчирчээ. Боомтын гааль хураах ба хасаж хэлтрүүлэх ажлыг сайтар хийх нь гадаадтай чөлөөтэй харилцах төрийн бодлогыг доошлуулан, улсын дотоодын үйлдвэрлэлийг ахиулах буюу хамгаалж гадаад аж ахуй арилжааг хөгжүүлэн, улсын эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэхэд цөм чухал үйлдэлтэй юм.

Гэвч далдуур арилжаалсан хуурмаглах, орлуулах зэрэг арга барил хэрэглэн гаалийг дарж гаалиас зайлж улсад их хэмжээний аж ахуйн сүйдэл авчирсан байна.

Зарим нь хилийн арилжаа, бараа солилцох арилжааны нэрээр далдуур арилжаалах, зарим нь гаалийг үлдээх, боомт дамжиж эд бараагаар шалтгаалж далдуур арилжаалах, зарим нь нэг цогцолбор хариултыг олон зүйлд хэрэглэх, зарим нь нэг онгоцонд хоёр адил бус газрын бараа тээвэрлэх хуудастай, зарим нь хуурмаг бичиг материал хэвлэж байцаалтыг аргацаах зэрэг арга барилаар гаалийг дарж гаалиас дутаадаг. Ж нь: 1950 оноос 1979 онд манай улсын хилийн боомтын баривчилсан далдуур арилжаалсан

хэргийн өртөг нь нийт 1,5 дүншигүр (дүнчүүр. Ц.Г.) төгрөг байж 1980 оноос 1983 онд далдуур арилжаалахаас болсон боомтын гааль ба үйлдвэр худалдааны гаалийн сүйдэл бараг 50 дүнчүүр төгрөгөөс давсан байна.

Бүртгэлийг үндэслэвэл 1992 онд далай дагуу эл газрын Дотоодыг хамгаалах хилийн хамгаалалтын салаа мөчир далдуур арилжаалсан хэргийг 2508 удаа байцаан баривчилж түүний дотор 100 түмэн төгрөгөөс дээших том хэрэг 106 удаа байж, далдуур арилжаалсан онгоцыг 1411 баривчилж 15 дүнчүүр төгрөгийн далдуур арилжаалсан өртгийг олзолсон байна. Далдуур арилжаалах ажиллагаа нь үндэсний аж үйлдвэрийн хөгжилтийг нөлөөлж, нийгэм журамт зах дэлгүүрийн аж ахуйг самууруулан улсын ашиг тусыг хүнд сүрхий эвджээ. 1979 оноос 1983 оны далдуур арилжаалсныг баривчилсан бүрэн бус бүртгэлийг үндэслэвэл бүх улсын далдуур арилжаалсан бодисын өртөг нь бараг 20 дүнчүүр төгрөг байжээ. Далдуур арилжаалж Сингапурт оршиж буй шижир алт, цагаан мөнгө, эмийн материалын өртөг нь 30 дүнчүүр сияанганг зоос болж, өөр газарт бас оршиж орсон байдаг.

Нэг талаар тэр нь хууль бусаар хилд оруулах бодист эд мөнгөний арилжааны нөхцөлийг бэлтгэж их хэмжээний телевиз, шингээлтийн машин, гар цаг, машин тэрэг, тамхи, нилүнг утас зэрэг манай улсын аж ахуйн бүтээн байгуулалтад бачим шаардагдахгүй бодисыг сохор балай хууль бусаар хилд оруулж, нөгөө талаар их хэмжээний төлөвлөгөөт

бодисыг хууль бусаар оруулж гаргаж, манай улсын бүтээн байгуулалтад тун их сүйтгэл учруулсан. Иймэрхүү хууль бусаар оруулж гаргахын үр дүн нь бас нэг зүйлийн сохор балай дур зоригийн хүчийг бүрэлдүүлж, улсын дотоодын зах дэлгүүрийг хүнд сүрхий нөлөөлдөг. Ж-нь: 1988 оны 8 сард манай гадаадаас оруулах тамхины боомтын гаалийг их хэмжээгээр дээшлүүлсэнд улсын дотоод ба гадаадын зах дэлгүүрийн гадаадын тамхины үнэ нь тун их зөрөөтэй болсон байна. Иймэрхүү далай дагуу орноос дотор газар хүртэл тамхи панзлах их урсгал үүсч энэ урсгалаас том бүлэг буй болсон. Баруун өмнөд орны нэг бүлэг тамхины панзчин нь бас нилээд нарийн чанга зохион байгуулалтыг байгуулж, энэхүү зохион байгуулалт нь дотооддоо урт аяны панзлан тээвэрлэх, ойр аяны панзлан тээвэрлэх ба тамхийг хүргэж тосохыг хариуцах зэрэг нарийн чанд ажлын хувиарлалтай байдаг. Тамхины зах дэлгүүр нь хязгаартай далдуур арилжаалж оруулсан тамхи нь боомтын гаалиас дутааж тамхины, тамхины зах дэлгүүрийг самруулж “нийт худалдааны тамхи”-ны эзлэх тоо хэмжээнд нөлөөлсөн байна.

1988 онд бүх улсын зах дэлгүүрт “нийт худалдаалах тамхи” 97 түмэн хайрцаг (хайрцаг бүр 500 боолт) эзэлж байснаас 1990 онд дорогшлоод 43 түмэн хайрцаг болсон байна. Үүнтэй харьцангуй харгалзал нь 1988 онд далдуур арилжаалсан тамхи бараг 200 түмэн хайрцаг байж 1990 он болоход далдуур арилжаалсан тамхи нь нэмэгдээд 350 боолт түмэн хайрцаг болсон байна. Далдуур арилжаалах хөдөлгөөн нь үндэсний аж үйлдвэрийн

хөгжилтөд нөлөөлөн харшилснаар барахгүй бас улсын гаалийн орлого ч их хэмжээгээр урсан гээгджээ. Ж нь: зарим нэг газар оронд 1979 онд улсын үйлдвэрлэсэн гар цаг 1220 г худалдаж байсан бол 1980 оноос 1985 оны 3 сар хүртэл үйлдвэрлэсэн бугуйн /гар/ цаг нэгийг ч худалдаалж чадсангүй. Үүний хамт манай улсын телевиз, машин тэрэг, дүрс шингээлтийн машин /камер/ компьютер зэрэг олон аж үйлдвэрийн салаа мөчир хүнд сүрхий сүрдүүлэлд учирч, цаашлаад үүдээ хааж болзошгүй байдаг. 1992 оны сүүлийн хагас жилээс 1993 оны эхний хагас жил болтол зөвхөн Сингапураар (Сияанганг) дамжин Думдад улсын эх хуурайд орж ирсэн машин тэрэг 6,1 түмэн байж үүнтэй адил хугацаанд хилийн боомтод тэмдэглүүлсэн нь зөвхөн 3 түмэн байж 3,1 түмэн машин тэрэг нь манай орны валютыг 9 дүнчүүр доллар урсан гээгдэж, 140 дүнчүүр төгрөгийн гаалийн орлого хасагдсан байна.

1992 оноос 1993 оны 4 сар хүртэлх охорхон 5 сарын хугацаанд зөвхөн күрэй (корей Ц.Г) Думдад улсад худалдан оруулсан машин тэрэг 21 түмэн байж, адил хугацаанд Думдад улсын хилийн боомтод тэмдэглүүлсэн машин тэрэг зөвхөн 200 илүү байж хоёр тоо нь 100 дахин зөрж, зөвхөн машин тэргийг далдуур арилжаалан оруулах нэг зүйл нь жилд урсан гээгдэх валют нь хэдэн арван дүнчүүр доллар хүрч 300 дүнчүүр төгрөгийн гаалийн орлого хасагдсан байна. Далдуур арилжаалах хөдөлгөөн нь манай улсын нийгмийн амар түвшний эмх дэглэмийг хүнд сүрхий самууруулж ялзлан доройтуулах гажуу суртлын

дэлгэрэхийг тусалж нийгмийн амар тогтууныг эвджээ. Хил, далай дагуу орны далдуур арилжаалах хөдөлгөөний өдрөөс өдөрт гаарахыг дагалдан булаан дээрэмдэх зодолдох хорлон алах, зэрэг ялт ажиллагааг дэлгэрүүлж далдуур арилжаалах ажиллагаагаар хүнд сүрхий байх газар орны эрүүгийн хэрэг гарах нь бусад газраас товойм өндөр байдаг. Үүний хамт хээл хахуул идэх, шамшин завших зэрэг нийгмийн гажуу суртлын дэлгэрүүлж кадр олныг ялзруулж нийгмийн ёс моралийг эвдэн, нам ба улсын ашиг тусыг халдан хөнөөсөн байна. 1987 оны 5 сарын 26 нд Төрийн явдлын хорооны түүхэн дурсгалт бодисыг хулгайлан малтах ба далдуур арилжаалах хөдөлгөөнд цохилт өгөх тухай мэдэгдэлд зааж гаргасан нь: “Ойрын хэдэн жилээс нааш манай улсын эл газарт түүхэн дурсгалт бодисыг далдуур арилжаалах ба эртний онгон хуучин буурь, үлдэгдлийг хулгайлан малтах ялт ажиллагаа олонтаа үүсч цөөн бус түүхэн дурсгалт бодис хулгайлагдан хил гаргаж, манай улсын соёлын үлдэгдэл хүнд сүрхий эвдэгдэлд учирснаар барахгүй, нийгмийн суртлыг эвдэн, нийгэм журамт бодисын боловсон ба оюуны бүтээн байгуулалтанд ч хохиролтой болно” гэсэн байна. Гэвч нэн хүнд сүрхий нь Юүнэний пинг ёован орон нь хэсэг хугацаагаар бүх улсын цорын ганцаараа эзэгнэсэн буу зэвсгийн худалдааны талбар болсон байна. Хэрмэн дээр өлгөж байгаа ширээн дээр дэлгэж байгаа, газар дээр дэвсэж байгаа нь цөм хүн амьтныг алах зэвсэг байж, гар буу, явган буу, пулемет, гар мина гранат, дэлбэрэх хонгио, бас

эл зүйлийн сум ба дуу замхруулагч, онилох дуран зэрэг байж их буунаас бүрдэж нүд эрээлжлэм болсон байна.

Тусгайлан энд ирж буу зэвсэг худалдан авах ялт этгээд тун амарханаар санаандаа хүрч дараа нь эдгээр буу зэвсгээрээ булаан дээрэмдэх, хүн алах зэрэг зэрэг ялт ажиллагаа хийж, орон даяар муу үр дүн нь хүрч хүнд эрүүгийн хэргийг үүсгэсээр байна. Хилийн гадаадад холбогдсон явдлын хэмжээ, төрөл зүйл жич мэдүүлэн зөвшөөрүүлэх эрх.

Хилийн гадаадад холбогдсон явдлын хэмжээ.

Хилийн гадаадад холбогдсон явдлын багтаасан агуулга нь нилээд өргөн дэлгэр байдаг. 1988 оны 11 сард нийтэлсэн “Бүгд Найрамдах Думдад Ард Улсын Засгийн ордон ба БНМАУ-ын Засгийн Газрын Думдад Монголын хилийн дүрэм тогтоол ба хилийн асуудлыг шийдвэрлэх тухай гэрээ” нд хоёр талын хилийн төлөөлөгчийн байцаах ба шийдвэрлэх чухал асуудлыг 11 талын асуулгыг багтаадаг. Даруй:

1. Хил давж буу харвах буюу эсрэг талын хил рүү буу харвасанаас болж нөгөө талын хил доторх хүнийг шархдуулан алах, эд хөрөнгө сүйтгэх,
2. Хилийн ойролцоо орны нөгөө талын хүмүүст хүчирхийлэл үзүүлэх
3. Хүн, нисэх машин ба бусад тээврийн багаж хэрэгсэл хууль бусаар хил давах жич орчин тойронд хөнөөл учруулах.
4. Эрх аваагүй хүн хууль бусаар хил давж харилцаа холбоо авах

5. Нөгөө талын хил доторхи эд бодисыг хулгайлах эвдэн сүйтгэх
6. Мал, нутгийн хил давах
7. Түймрийн аюул нөгөө талын нутаг дэвсгэрт орох
8. Хилийн тэмдэг, дагалдуулал тэмдэг ба зааг шугамын тэмдэг эвдэгдэн сүйтгэгдэх, шилжигдэх буюу үгүй болох.
9. Ямар нэгэн хилийн хэрэг явдлын үр дүнгээс болж нэг талаас дурьдсан төлбөрийн асуудал
10. Хүчин бүхий хилийн асуудлын гэрээ хэлэлцээр ба зөвшилцлийн бичгийн тогтоолыг зөрчих
11. Гадаад харилцааны арга замаар шийдвэрлэх чухалгүй бусад хилийн асуудал

Дөрөв. Хилийн гадаадад холбогдсон явдлын төрөл зүйл.

Хилийн гадаадад холбогдсон явдлыг түүний улсын ашиг тусыг хөнөөсөн дэс дарааллыг үндэслэн ердөө гурван төрөлд хуваадаг.

нэг. Хүнд хэрэг. Голдуу хөрш зэргэлдээ улс манай улсын нутаг дэвсгэр, харъяат далайн эрх мэдлийг түрэмгийлэх, зэвсэгт түрэмгийлэл, өдөөлгө хийх, манай талын хүнийг алж шархдуулах жич маргаантай газар оронд хилийн одоох байдлыг зөрчиж, хөдөлгөөний хэмжээгээ өргөтгөх зэрэг явдлыг зааж байна.

хоёр. Энгийн гадаадад холбогдох асуудал. Хүн машин тэрэг, мал унаа, онгоц сал зэрэг хил давах хилийн оронд цэргийн явдлын холбогдол хийх ба үнэн сумын харвалт хийх зэрэг манууст хүнд хохирол болгосон үгүй байдал зааж байна.

гурав. Хилийн ажил хэргийн

асуудал. Гэрээ хэлэлцээр буюу зуршил ёсоор эсрэг талынтай зөвшилдөх хүн мал унаа, онгоц сал эд бодис зэргийг тушаах цаг, газар орон, арга алхам дарааг хэлэлцэн хилийн тэмдгийг засах арга ба хилийн төлөөлөгчийн ажлын дүрэм зэрэг ажил хэргийн шинжтэй асуудлыг зааж байна.

Гурав. Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэхэд мэдүүлэн зөвшөөрүүлэх эрх.

Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх нь улсын эрх мэдэл ба хөрш улсын харьцаатай холбогддог. Улс ба төвийн голлон хамаарах салаа мөчрөөс хилийн гадаадад холбогдох явдлыг дээд хэмжээгээр нэгдэлтэй удирдахын төлөө хилийн гадаад холбогдох явдлыг шийдвэрлэх эрхийн хязгаарт чанга тогтсон байдаг.

Нэг. Хилийн явдал, нутаг дэвсгэр, харъяат далайн харъяалагах явдал ба эсрэг ба эсрэг талын хүн манай талын хүнийг алж шархдуулах явдалд холбогдох жич хилийн хамааралтад холбогдох, гэрч тэмдэг визгүй хүмүүс хилд орж болох эсэх зэргийг багтаасан хүнд их хилийн гадаадад холбогдох явдлыг муж, өөртөө засах орны ард засгийн ордон, төвийн голлон хамаарах салаа мөчир буюу төвөөс хянан зөвшөөрнө.

Хоёр. Эсрэг талын хүмүүс хилийн одоох байдлыг эвдэх маргаантай газар оронд манай хайн цагдах, явж нэвтрэх, ажил үйлдвэрлэл хийх зэрэг хөдөлгөөнийг хориглон харшилж, хилийн хамгаалалтын хэлэлцээр, уулзалтын дүрмийг өөрчлөх зэрэг хилийн гадаадад холбогдох асуудлыг голлон хамаарч байгаа салаа мөчир

муж, өөртөө засах орны засгийн ордон, мужийн цэргийн тойрогт мэдүүлж хянан зөвшөөрөхийн хамт төвийн голлон хамаарах салаа мөчирт мэдүүлэх хэрэгтэй.

Гурав. Чухал агуулга ба энгийн хэлэлцээр жич туслан аврах, нөхөрсөг найр үдэшлэгийн хөдөлгөөнийг муж, өөртөө засах орны дотоодыг хамгаалах тэнхим, гадаад явдлын албан гэрээр хянан зөвшөөрүүлэхийн хамт дотоодыг хамгаалах яамны хилийн хамгаалалтын товчоонд мэдүүлэх хэрэгтэй

Дөрөв. Чухал хэлэлцээр буюу муж, ардын орон алсарсан тойрон үзэх хөдөлгөөнийг дотоодыг хамгаалах яаманд мэдүүлэх хянан зөвшөөрүүлэх хэрэгтэй.

Тав. Энгийн гадаадад холбогдох хөдөлгөөн, ж-нь хүн, эд бодисыг солилцож, энгийн гадаадад харилцах, мэдэгдэх зэрэг ажиллагааг муж өөртөө засах орны дотоодыг хамгаалах тэнхимийн хилийн хамгаалалтын товчоогоор хянан зөвшөөрүүлнэ.

Зургаа. Дээд шатнаас нэгэнт шийдвэрлүүлэх эрх олгосон энгийн гадаадад холбогдох явдлыг газар хот зеу ийн Дотоодыг хамгаалах газар \ товчоо\ын хилийн хамгаалалтын \ хувиар\ товчооноос зөвшөөрүүлэхийн хамт зохион байгуулж хэрэгжүүлнэ.

Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх гол хамаарах байгууллага, зарчим ба үндэслэл.

Нэг. Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх гол хамаарах байгууллага.

1983-2-18-нд Төрийн явдлын хороо, Төвийн цэргийн явдлын хорооноос Ерөнхий штабын газар, Дотоодыг

хамгаалах яамны зөвшөөрсөн “Думдад-Зөвлөлт, Монгол, Энэтхэг, Вьетнам... зэрэг хилийн орны Думдад улсын ардын чөлөөт цэргийн хилийн хамгаалалтын цэрэг, анги ба ардын хилийн хамгаалалтын зэвсэгт цагдаа, цэрэг ангийн ажлын хувиарын тухай тогтоол”-д Манай улсын эх хуурайн хилийн сэргийлэн хамгаалах үүргийг Дотоодыг хамгаалах хилийн хамгаалалтын салаа мөчир ба Ардын чөлөөт цэргийн хилийн хамгаалалтын цэрэг анги, хамтаар үүргэлж бүр өөр өөрийн чухалчлах тал байдаг. Думдад-Солонгос, Думдад-Бирм ба хөршлөн залгалдаж байгаа Сияангганг, Уомен хилийн хамгаалалтын үүргийг Дотоодыг хамгаалах хилийн салаа мөчрийн хариуцахын хамт бас дотоодыг хамгаалах төлөөлөгч ба хилийн хамгаалалтын төлөөлөгчийн дүрэм байгуулж, гадаадад холбогдох явдлын бодитой ажлыг шийдвэрлэхийг хариуцна. Думдад-Вьетнам, Думдад -Лаосын хилд хилийн хамгаалалтын төлөөлөгчийн дүрмийг байгуулж, хилийн гадаадад холбогдох явдлыг нэгдэлтэй шийдвэрлэхийг хариуцна. Думдад Зөвлөлт, Думдад Монгол, Думдад Энэтхэг зэрэг хилд чөлөөт цэргийн хамгаалалтын цэрэг анги нэгдүгээр утасны сэргийлэлийн үүргийг хариуцахын хамт, хилийн хамгаалалтын төлөөлөгчийн дүрэм байгуулж, хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэхийг хариуцна. Дотоодыг хамгаалах салаа мөчрийн ажилтай холбогдох үед (жишээлбэл: хүн, хүүр үхдэлийг тушаан солилцох зэрэг) Дотоодыг хамгаалах хилийн хамгаалалтын салаа мөчир хүн

томилон уулзалт ба хэлэлцээрийн ажилд оролцоно. Хилийн хүмүүс хил өнгөрөхтэй холбогдох ба зам харилцааны багаж хэрэгсэл жич түүнийг тээвэрлэж байгаа эд бодисыг хилд орох байцаалт дунд үүссэн гадаадад холбогдох асуудлыг Дотоодыг хамгаалах хилийн хамгаалалтын салаа мөчир хариуцан шийдвэрлэнэ. Думдад - Зөвлөлтийн хил нь одоо нэгэнт Думдад -Орос, Думдад-Казакстан, Думдад -Киргизстан, Думдад-Тажикстаны хилээр орлогджээ. Гэвч манай улсын хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх хамаа бүхий тогтоол нь мөн угийн Думдад Зөвлөлтийн хилийн тогтоолыг хэрэгжүүлнэ. Газар орны гадаад явдлын албан гэр бол гадаадад холбогдох ажлын системчлэх салаа мөчир байж чухал их гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэхэд жолоодох хариуцлагатай. Дотоодыг хамгаалах Хилийн хамгаалалтын салаа мөчир, чөлөөт цэргийн хилийн хамгаалалтын цэрэг анги, гадаад явдлын албан гэр бол манай улсын хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх гол салаа мөчир болно.

Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх зарчим.

Нэг. Зарчмыг баримталж тэмцлийг баримтлах нь.

Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх нь төрийн бодлогот чанараар тун чанга байж, эрхиш улсын хууль цааз, хууль зарлиг, төрийн бодлогыг тогтоол ба хөрш улс лугаа тогтоосон холбогдол бүхий гэрээ хэлэлцээрийг үндэслэж, хилийн гадаадад холбогдсон явдал ба холбогдол бүхий асуудлыг зөв

шийдвэрлэх хэрэгтэй. Хүнд чухал гадаадад холбогдох асуудалд эрхиш зарчмыг баримтлан, тэмцлийг баримталж, “Ёстой ашигтай” байх хэрэгтэй. Энгийн шинжтэй гадаадад холбогдох асуудалд, адил бус байдал, адил бус шинж чанарыг үндэслэн, адил бус арга хэрэглэж, амьдлаг тохитой шийдвэрлэх хэрэгтэй.

Хоёр. Үнэнийг баримталж ёсоор хүнийг бишрүүлэх нь.

Хилийн явдлаар харилцах үед, зарим асуудлыг нэн сайн шийдвэрлэхийн төлөө, эрхиш үнэнийг баримталж, ёсоор хүнийг бишрүүлэх зарчмыг баримтлах хэрэгтэй.

Зарчмын асуудлыг хэлэлцэх буюу эсвэл бодитой явдлыг хэлэлцэхэд, цөм бодит хэргийг гаргаж, ёс учрыг тайлбарлах хэрэгтэй. Ингэвэл сая жишсэн зорилгодоо хүрч чадна. Хүн, мал унаа, түймэр зэрэг энгийн хил давсан хэрэгт үнэнийг баримтлах оврыг хэрэглэж ингэх нь эсрэг талын ойлголтыг олж чадах, мөрдөөн манууст бас тийм их нөлөө болж чадахгүй юм.

Гурав. Зүй ёсонд нийцэж, эрх тэгшээр зөвлөлдөх нь.

Хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэх дунд, онцгойрон баяр дурсгалын өдрийн нөхөрсөгявалцаа ба эсрэг талтай хэрэг явдал зөвлөлдөх үед, эрхиш зүй ёсонд нийцэж, эрх тэгшээр зөвлөлдөн харилцан ойлголцож, харилцан найр тавих зарчмыг баримталж, эсрэг талтай нарийн хянамгай зөвлөлдөхийн хамт, эсрэг талын зүй ёсны саналыг хүлээхийг анхаарч, манай талын бодит хүчирдэл, бодитой байдалд ба шаардлагаа хүчирдэл ба зүй ёсны шаардлагад,

манай эрх ашгийг хөнөөхгүй нөхцөлд, бодит байдлаа үндэслэн зохих хэмжээгээр бодолхийлэх ба харгалзах хэрэгтэй.

Дөрөв. Нууцыг хамгаалахыг анхаарч, дотоод гадаадыг ялгаатай байлгах нь.

Хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэхэд оролцох хүн бүхэн төрийн бодлогын тогтоолыг чанд сахиж, эх нутагтаа үнэнч, ард түмэнд үнэнч байж, улсаа хайрлах үзлийг бадруулж үндэстний нэр хүндийг хамгаалж, эх улсад ашиггүй явдлыг хийхгүй, эх улсад ашиг тусгүй үг яриаг ярихгүй байх хэрэгтэй. Гадаадад холбогдох хөдөлгөөний дунд, эрхбиш дотоод гадаадын ялгаатай байх зарчмыг нарийн хянамгай хэрэгжүүлэх. Гадаадад овроо илэрхийлэх үед нэгдэлтэй хэллэгээр илэрхийлэх. Улсын дотоодод илээр нийтлэхгүй аливаа хэрэг явдлыг дээд шатны зөвшөөрөлгүйгээр ямарваа хүн гадагш задруулж болохгүй. Ямарч байдалд хэлж болохгүй үгийг яасан ч хэлэхгүй, хийж болохгүй явдлыг яасан ч хийхгүй байхыг бат цээжилж, хүнд өө сэвээ илрүүлэхгүйг хичээж, идэвхгүй болохоос сэргийлэх

Тав. Өөрийгөө гол болгож, өөрийн эрхээ эзэмших

Хилийн хамгаалалтын гадаад харилцаан дунд, онцгойлон баяр дурсгал ба тойрон аялах зэрэг нөхөрсөг хөдөлгөөн дунд эрхбиш өөрийгөө гол болгох зарчмыг баримтлан, эсрэг талын нөлөөнд орж болохгүй. Эрхбиш лавлаад, сэргэг зоригтой, шулуун байж, өөрийн эрхээ эзэмших. Чи чинийхээ ярь, би өөрийнхөө хэлнэ. Муу хэлэх гэснээ аргалж байгаад хэлж гаргаж,

миний хийх гэснээ арга бодож байгаад хийж бүтээнэ.

Зургаа. Цаг тухайд нь хариу мэдүүлж заавар авах зарчмыг баримтлах нь.

Хилийн гадаадад холбогдсон явдал бол ерөнхий байдалд холбогдох болохоор, түүний төрийн бодлогот чанар, цаг хугацаат чанар нь цөм тун чанга байдаг. Иймээс эрхбиш төрийн бодлогын хариуцлагат сэтгэлийг чангатгаж, зохион байгуулалтын ёс, сахилгыг чангатган, хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэхэд их бага гэлгүй, эрхбиш хариу мэдүүлж заавар авахад эрхбиш цаг тухайд нь оновчтой байж, даруй гадаадад холбогдох явдал үүсмэгц эрхбиш даруй түүхэн байдлыг байцаан тодорхойлж, оновчтой хянан магадалж, цаг тухайд нь дээш мэдүүлж, байдлыг нуухгүй буюу хуурмагаар мэдүүлж болохгүй. Чухал дийлэхгүй, бачим тулгам асуудлыг шат алсалж шууд дээш мэдүүлж болно. Барин доороо байцаан тодруулж болохгүй зарим асуудлыг нэг талаар дээш мэдүүлж, нэг талаар байцаан магадалж болно. Урьдаар товч мэдүүлэлт хийж, дараа нь нарийн мэдүүлэлт хийнэ. Гадаадад холбогдох явдлыг дээд шатны заавар ба шаардлага ёсоор шийдвэрлэж, дураараа буюу эрхээсээ давж шийдвэрлэж болохгүй.

Долоо. Гадаадад нөхөрсөг байх ба ухуулгын ажлыг сайтар хийх нь.

Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэхэд үргэлж хөрш зэргэлдээ улсын хүмүүстэй явалцан харилцдаг. Баяр дурсгалын өдөрт баяр хүргэх, эсвэл гадаадтай хэлэлцээр хийхэд цөм бодитой байдалд улсын харилцааны

одоохи байдлаас үүсч, төлөвлөгөөтэй, дэс дараалалтай явуулж, хөдөлгөөний зүйлийг хэт олон байгуулахгүй, бас удаа бүрийн уулзалт хийх бүрд заавал хөдөлгөөн тохируулсны хэрэггүй

Уур амьсгалын байдлыг зохистой байгуулах. Манай талын хүн урилгаар эсрэг талын хөдөлгөөнд оролцох үеэс, эрх тэгш зарчмыг бодолхийлж, биднээс эсрэг талд адилавар шинжтэй хөдөлгөөнийг тохируулж аргагүй байдалд эвтэй сайхан үгээр зайлсхийх хэрэгтэй.

Хэлэлцээр буюу дурсгалын өдрийн дайлагын хөдөлгөөн нь цөм нарийн нямбай урьдчилсан төсөв зохиож, адил бус дүйшээнд чиглүүлэн, зөв талын ухуулга ба эсрэг талыг ойлгох ажлыг хийх.

Манай улсын гадаад дахь нөлөөгөө өргөтгөх. Ухуулгын дунд үнэнийг дэлгэж, ёс чрин, арга маягийг амьдлаг байгуулж, байдлын аяар байж, үр дүнг чухалчлах.

Хэлэлцээр дунд хоёр улсын харилцааг сайжруулах зарчмыг барьж, эсрэг талын ард түмний гэрэл цацрангүй түүх ба үндэсний сэтгэлгээг хүндэтгэнэ. Эсрэг талын улсын удирдах хүнийг нэр дуудан шүүмжлэх, улсын дотоодын төрийн бодлогыг шүүмжлэн буруушааж болохгүй.

Эсрэг талын хүн буруу үг ярих, буруу явдал хийх буюу эсвэл манууст буруу ойлголттой үеэс, зориудаар өдөөлгө хийгээгүй бол мануус хэрэг явдлын бодит байдлыг хэлж тодорхойлохоос бус, шүүмжилж болохгүй. Хэрэв эсрэг тал зориуд өдөөлгө хийсэн байвал, эрс эсэргүүцэж няцааж, зууралдсаны хэрэггүй.

Эсрэг талтай харилцах дунд, боловсныг эрхэмлэн, ёс моралыг анхаарч, өмсгөл зүүдэл цэвэр тэгш, хөдөлж байх эвтэй гутрахгүй, ихэрхэхгүй байх хэрэгтэй.

Гурав. Хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэх үндэслэл.

нэг. Нам ба улсын тогтоосон гадаад харилцааны ажлын чиглэлт ба төрийн бодлогыг үндэслэх нь

Нам ба улсын тогтоосон гадаад харилцааны ажлын чиглэлт ба төрийн бодлого бол мануусын хилийн гадаадад холбогдсон явдлыг зөв оновчтой шийдвэрлэх ерөнхий жолоодох хууль дүрэм ба үндэслэл болно. Манай улс бол тусгаар тогтнож өөртөө эзэн мэдэх гадаад харилцааны төрийн бодлогыг хөгжүүлж байдаг.

Эзэрхэх үзлийг эсэргүүцэн, дэлхийн энх тайвныг хамгаалж, эл улстай нөхөрсөг хамтарч аж ахуйгаа хөгжүүлэн ахиулах нь манай улсын гадаад харилцааны ажлын үндсэн харилцаа болно.

Хилийн гадаадад явдлыг шийдвэрлэх ажиллагаан дунд гадаад харилцааны ажлын ерөнхий чиглэлт, ерөнхий төрийн бодлого ба харилцан хүндэтгэж, найрамдлаар зэрэгцэн орших таван зарчмаар үндэслэл болгох суурин дээр, эл улстай нөхөрсөг хөршийн харилцаагаа хөгжүүлэн ахиулна.

Ах дүү ба нөхөрсөг улстай хамтын ажиллагаагаа чангатган ард түмний хоорондох нөхөрлөлөө ахиулж, халуумсаг нөхөрсөг, даруу хичээнгүй байж, бүлгэмдлээ чангатгах мөрдөөн бас зарчмыг баримтална.

Дотоод гадаадыг ялгаж, хамтаар

хилийн амар тогтууныг хамгаалж хэрэгтэй. Эзэрхэг үзэлтэй тэмцэх, тэмцлийн дунд арга бодлогыг анхаарч, ялгаатай хандаж, гол, дэдтэй, ашигтай, байх ёстой.

хоёр. Улсаас тогтоосон хилийн хамгаалалтын төрийн бодлогын тогтоолыг үндэслэх нь

Улсаас хөрш зэргэлдээ улсын шинж чанар, түүний гадаад харилцааны төрийн бодлого ба манай улсын харьцаа зэрэгт чиглэж тус бүрдээ хилийн хамгаалалтын төрийн бодлогыг тогтоосон байна. Энэ бол мануусын хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх гол үндэслэл ба ажиллагааны баримжаа болно

Хилийн хамгаалалтын төрийн бодлогын тогтоол нь манай улсын гадаад харилцааны ажлын зарчим ба зогсолтгүй ажиллагааны баримжаа юм.

Хилийн хамгаалалтын төрийн бодлогын тогтоол нь манай улсын гадаад харилцааны ажлын зарчим ба зогсолтыг тусгажээ. Хилийн хамгаалалтын төрийн бодлогыг үндэслэн хилийн гадаадад холбогдох асуудлыг шийдвэрлэх бол манай ажлын шууд үндэслэл ба зарчим болно.

гурав. хоёр улсын хооронд тогтоосон гэрээ хэлэлцээр ба хилийн дүрэм хэлэлцээрийг үндэслэх нь.

Хилийн гэрээ хэлэлцээр ба хилийн дүрэм тогтоол бол зохих хуулийн хүчинтэй байж эл улсад зөвшөөрөгдсөн бөгөөд хоёр улсад адилхан хязгаарлах хүчинтэй юм.

Гэрээ хэлэлцээр, хилийн дүрэм тогтоол нь хилд үүсэх явдал жич түүнийг шийдвэрлэх арга хэмжээнд цөм зохих нарийн нягт тогтоол

тогтоосон байдаг.

Гэрээ зөвшилцөл, хэлэлцээрээр хилийн гадаадад холбогдсон явдлыг зөв шийдвэрлэх нь улсын эрх мэдэл, амар тайвныг хамгаалж, хилийн амар тогтууныг хэвээр байгуулахад цөм чухал их үйлдэл үзүүлж байдаг.

Хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэх арга маяг ба дэс дараалал.

Нэг. Хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх арга маяг.

Нэг. Захидлын арга маяг. Хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэх дунд, захидлаар харилцах буюу зөвшилцөх бол ердийн хэрэглэдэг нэг зүйлийн ажлын арга маяг болно.

Онцлог нь амьдлаг түргэн хэрэглээний хүрээ хэмжээ нь өргөн болно. Ж-нь: хүн хүүр үхдэл, эд бодисыг тушаан солилцох цаг, газар орон зөвлөлдөх эсвэл уулзалт хийх, хэлэлцээр хийх цаг, газар орон, хүнийг мэдэгдэх урьж залах холбогдол бүхий байдлыг мэдэгдэх зэрэг цөм хэрэглэж болно.

Хоёр. Хэлэлцээр, уулзалт хийх арга маяг. Хилийн хэлэлцээр, уулзалт бол хилийн гадаадад холбогдох явдлыг шийдвэрлэх гол ажлын арга маяг болно. Бас ч хоёр талын хилийн явдлыг шийдвэрлэх арга зам болно. Хоёр талаараа хил дээр гарсан асуудлыг цаг тухайд нь зохистой шийдвэрлэхийн төлөө, ердөө хэлэлцээр, уулзалт хийх ажлын дүрмийг байгуулсан байна.

Хилийн хэлэлцээр, уулзалт бол адилавар мөртлөө бас ялгаатай хоёр ухагдхуун болно.

Уулзалт нь энгийн байдалд хоёр талын холбогдол бүхий хүмүүс тогтсон газар оронд болзон уулзаж, холбогдол

бүхий эрхэт байгууллагын санал зөвлөгөөг дамжуулан тоочихыг зааж байна.

Хэлэлцээр нь Хилийн хоёр талын адил тэгш холбогдол бүхий хүмүүс адил дэсийн төлөөлөгчөөс урьд нь нэгдэн тогтсон ямар нэгэн асуудлын тухай зөвлөлдөж ярилцахыг зааж байна. Энгийн байдалд хэлэлцээр нь үсэг бичгийн хэлэлцээр буюу аман хэлэлцээр гэж байгуулж болдог.

Эсрэг талтай хэлэлцээр хийхэд урдаар төсөв тогтооно. Хэлэлцээрийн зөвлөх сэдэв, ярилцах арга, жич ярих хүнээ тогтоож, тогтоолын ёсоор дээш мэдүүлэн зөвшөөрүүлнэ. Зөвшөөрсний дараа барин түргэн хэрэгжүүлнэ.

Гол ярих хүн холбогдол бүхий төрийн бодлого ба гадаадад холбогдох ёс дүрмийг нарийн хянамгай хэрэгжүүлнэ. Гол ярих хүн холбогдол бүхий төрийн бодлого ба гадаадад холбогдох ёс дүрмийг нарийн хянамгай суралцаж, дээд шатны зааврын үзэл санааг ойлгосны суурин дээр төсвийг олонтаа судалж үүсч мэдэх байдлыг шийдвэрлэх урьдчилсан төсөв тогтоож, гадаадад ярих яриагаа нэгтгэж, хамаа бүхий гэрч баримт, материалыг бэлтгэж, заримдаа гэрээ хэлэлцээрийг үндэслэх ултай хэлэлцэх агуулга газраа урьдчилан мэдэгдэж, хоёр талаараа цөм бэлтгэлтэй байх нь асуудлыг түргэн шийдвэрлэхэд дөхөм байдаг.

Хэрэв эсрэг талаас манийг урьж уулзалт хийхэд мэдүүлэлт хийж амжихгүй бол хүнийг тэвчихгүйгээр урдаар уулзалт хийж, эсрэг талын санааг ойлгосны дараа дахиж мэдүүлж болно. Хэлэлцээр дунд зөвшөөрсөн төсөв ёсоор асуудлыг зөвлөлдөн

шийдвэрлэнэ.

Зарчим баримтлах мөрдөөн бас төсвийг үндэслэн эл зүйлийн байдлыг амьдлагаар шийдвэрлэж, голтой, дэдтэй урагшлах бөгөөд бас найр тавьж, эрх тэгш зарчмыг журамлан жишсэн зорилгодоо хүрэхээр чармайна.

Хэлэлцээр уулзалтын дунд хэрэв эсрэг талаас төсвөөс гаднах асуудлыг ярилцах үед дураараа оврын илтгэх буюу зөвшөөрөн хүлээж болохгүй. Хэрвээ дээд шатны журамлах зарчим үндэслэлгүй бол адил бус байдлыг ялган салгаж, судлах, мэдүүлэх буюу эвтэй үгээр давчвал зохино. Хэрэв эсрэг талаас өдөлгө хийхүед эрс эсэргүүцэж, зохих тэмцэл явуулахын хамт улам нэг алхам харилцах эрхээ хадгалж байхаа тодорхойлно.

Хэлэлцээр дууссаны дараа манай талын хүмүүсийг зохион байгуулж хэлэлцээрийн байдалд бага дүгнэлт хийнэ. Агуулгыг голдуу олсон ололт, анхаарах асуудал жич эсрэг талын байдал ба задлалтыг багтаана. Дүгнэлтийн мэдүүлэлт бичиж цаг тухайд нь дээш мэдүүлнэ. Хэлэлцээр уулзалтын дунд бусад салаа мөчиртэй холбогдох ажил байвал цаг тухайд нь холбогдол бүхий салаа мөчирт мэдэгдэнэ.

Гурав. Тухайн газарт нь шийдвэрлэх нь.

Хилийн ойролцоо илрүүлсэн асуудлыг хоёр талын холбогдол бүхий гэрээ хэлэлцээрийг үндэслэн, тухайн газарт нь шийдвэрлэж болно. Жишээлбэл: хилийн ойролцоо эсрэг талын мал унаа хил давж манайд орж ирсэн тухайн газарт нь хөөж буцаах, хилийн ойролцоо барьж олзолсон эсрэг

талын хууль бусаар хил давсан хилийн иргэн, манууст бусад хор хөнөөл учруулсангүй бөгөөд бусад сэжигтэй байдалгүй бол тэр доор нь түүний бурууг зааж гаргаж, зарлигдан буцааж болно

Гэвч нарийн нямбай данслан тэмдэглэж, дээд шатанд мэдэгдэж, хэргийн дараа буюу зохих тохиромжтой цагт эсрэг талд мэдэгдэх хэрэгтэй.

Дөрөв. Гадаад харилцааны арга зам.

Энгийн байдалд хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэхэд хоёр талын хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэхэд хоёр талын хилийн хамгаалалтын байгууллагатай харилцаж байгаад шийдвэрлэнэ.

Чухал их байдал, хүнд чухал хэргийг бас хилийн хамгаалалтын газрыг давж шат алгасан, гадаад харилцааны арга замаар, хоёр улсын Засгийн газраас хэлэлцэн зөвлөлдөж шийдвэрлэх болно.

Гадаад харилцааны арга замаар дамжин хилийн гадаадад холбогдсон асуудлыг шийдвэрлэх бол нэг зүйлийн дээд дэсийн асуудлыг шийдвэрлэх хэлбэр болно.

Хоёр. Хилийн гадаадад холбогдсон явдлыг шийдвэрлэх дэс дараалал

Нэг. Хил дээр гадаадад холбогдсон явдал буюу хэрэг үүсэх үед, хилийн хамааралтын салаа мөчир даруй түргэн хүн томилон хэрэг гарсан газар оронд хүрч хайн байцаах, гэрч авах, хэрэгтэй.

Хэрэг гарсан газрын нэрийдэл, орон байрыг байцаан тодорхойлсны дараа хайн байцаах хүмүүсийг зохион байгуулж тухайн газрын холбогдол бүхий ор мөр, үлдэгдэл бодисыг

сүүдэрлэж зурах ба гэрч авна...

Хоёр. Тухайн хүн, байдлыг мэдэх хүн буюу олж мэдсэн хүнийг даруй түргэн эрэн олж, хэргийн үүссэн шалтгаан, өнгөрсөн ба олж мэдсэн явцыг ойлгохын хамт байцаалт хийнэ. Байцаалтын дунд ба нарийн нямбай асууж дахин давтан хянан магадалж, ямарч нарийн хэсгийг ч алдаж гаргаж болохгүй. Хэргийн шинж чанар ба шалтгааныг тодорхойлж, холбогдол бүхий хүмүүсийн гэрч үг, буюу тушаасан материалаа бичихийг шаардана.

Гурав. Цаг тухайд нь дээд шатны голлон хамаарах салаа мөчирт байцаасан дүнгээ бичгээр мэдрүүлнэ. Мэдрүүлэлтэнд гадаадад холбогдсон явдал буюу хэргийг үүсгэсэн цаг, газар, хүн шалтгаан, үр дүн жич шийдвэрлэх саналаа дээд шатанд мэдүүлж, чухал үед газар хүн орон байрын зураг буюу тухайн газрын хавтгай дэлгэсэн зураг жич бусад гэрч баримтыг дагалдуулж дээд шатны зааврыг хүлээнэ.

Дөрөв. Гадаадтай харилцахад урдаар төсөв тогтоож урьдчилан төсөв бэлтгэнэ. Хэлэлцээрийн үүрэг тодорхой болсны дараа эсрэг талын байдлыг нарийн нямбай задалсны суурин дээр даруй түргэн хэлэлцээрийн төсөв тогтоож, дээд шатанд мэдүүлж хянан зөвшөөрүүлнэ. Дээд шатны зааврын зориг санааг ойлгохын хамт бусад бэлтгэл ажлыг хийнэ.

Тав. Шийдвэрлэх ажил дууссаны дараа цаг тухайд нь ажлын байдлаа дүгнэн үсэг бичгийн мэдүүлэг бичнэ.

1970-аад оноос эхлэн БНХАУ нь хил орчмын ард иргэдийгээ хил хамгаалалтанд ХКНам, төрийн

бодлогоороо татан оролцуулж байсан бөгөөд “Хил орчмын даган сэргийлэх хариуцлагын дүрэм” боловсруулж хил орчим оршин суугч иргэдтэй хатуу гэрээ байгуулан ажилладаг байна.

Хил орчмын даган сэргийлэх хариуцлагын дүрэм

“Үндсэн хуулийн холбогдол бүхий зурвасыг үндэслэж эв хамт намаа хүрээлж эх улсаа хайрлан, дөрвөн үндсэн зарчмыг баримтлан хил хязгаараа батлан хамгаалж, “Тавын эсэргүүцэх” тэмцлийг сайтар хийхийн төлөө тус дүрмийг тогтоов.

1. Хил хамгаалалтын төрийн бодлого, дүрэм тогтоолыг чанга нямбай хэрэгжүүлж, хүн, мал хил давахыг сэргийлэн хориглоно.
2. Дотогш шургалан гадагш зугтаанч дайсныг барихын хамт нааш цааш явах хүмүүс, тэрэг хөсөгний гэрч тэмдгийг ялган байцааж, гэрч тэмдэггүй хүмүүсийг явуулахгүй сэжигтэй хүн илэрвэл арга сүвэгчлэн тогтоож, хилийн салбарт түргэн мэдэгдэнэ.
3. Гадагш зугатах бололтой сэжигтэй хүмүүсийг хянан ажиглаж, сэжигтэй байдал илэрвэл, гадагш зугатахаас сэргийлнэ.
4. Дайсны тагнуул, дотогш шургалан гадагш зугтаасан сэжигтэй ба хамт хэрэг үйлдсэнийг мэдвэл, хэргийн газар мөр, эд хэрэглэлийг уул хэвээр хадгалахын хамт, хэрэгтнийг илчлэн баривчлах ажилд хамжилцана.
5. Хил орчмын хамааралтын дүрмийг хэрэгжүүлнэ. Гадагш гарахдаа чөлөө авч, зочин ирвэл мэдүүлнэ. Нааш цааш явахдаа хилийн тэмдэг

авч, байцаалтыг хүлээнэ.

6. Дайсны радио нэвтрүүлэг болон бусад төрлийн тэрслүү ухуулгыг сонсож дамжуулахгүй. Хөрөнгөтөн ангийн үзэл санааны ялзралыг эсэргүүцэж, оюун санааны бузартлаас сэргийлнэ.
7. Хилийн багана, овоо тэмдэг, хилийн зааг, шугам хөвөөг хамгаалж, хэрвээ шилжүүлсэн, эвдсэн учрал гарвал, даруй дээш мэдүүлж хилийн багана ба хилийн заагаа батлан хамгаална.
8. Дээрх тогтоол дүрмийг холбосон сэргийлэх дугуйлангийн гишүүн болон гэр бүлийнхэн харилцан хянаж, хамтаар хэрэгжүүлнэ. Гавьяа шагнал гаргасныг хөхүүлэн шагнаж, зөрчигчдыг яллан торгоно. Тус дүрмийг зөвшөөрөн батлав. Дугуйлангийн гишүүн Өнөрцэцэг.

Тойргийн цагдагч Энхээ.

19... оны 5 дугаар сарын 01

1970 аад оны дунд үеэс эхлэн БНХАУ-д “Боловсон айл гэрийг бүрдүүлэх нөхцөлийн 5 зүйл”-ийг мөрдөж эхэлсэн ба уг зүйлийн 4-д Цэрэг, цагдаа, ардын холбоо харилцаа болон бусад айл өрхтэйгээ эе эвийн энэрэнгүй харьцаа холбоотой байх, хил орчмын төрийн бодлого дүрэм тогтоолыг үлгэр жишээгээр сахиж, хүн малаа хил давуулахгүй байх гэж зааж өгсөн байдаг.

БНХАУ нь улсын хилийг бүх нийтээр хамгаалах болон “Хоёр улс-нэг хил” бодлогыг хэрэгжүүлдэг.

Дүгнэлт:

1. БНХАУ-д хил судлалын шинжлэх ухаан “Хил хамааралтын ухаан” нэртэйгээр өндөр түвшинд хөгжиж байна.

2. БНХАУ-ын Төрийн хилийн бодлого нь олон улстай хиллэдэг учраас улс бүртэй харилцах харьцаа, баримтлах хилийн бодлогыг улс бүрийн онцлогт тохируулан боловсруулжээ.
3. Улсын хилийн болон хилийн дэглэмийн зөрчлөөс урьдчилэн сэргийлэх ажлыг иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын нягт хамтын ажиллагаагаар уялдан зохицуулж байна.
4. Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчилд эрүүгийн болон захиргааны хариуцлагыг ноогдуулан шийтгэж байгаа бөгөөд эрүүгийн хуулийн 6 заалтад тусгажээ.
5. “Хил хамааралтын ухаан” номыг уйгаржан монголоос кириллд хөрвүүлсэн бөгөөд албан хэрэгцээнд хилчдэд зориулан хэвлүүлэн ашиглах нь эсрэг талынхаа хил хамгаалалтын бодлого, арга тактик, ажиллагааг танин мэдэхэд маш чухал ач холбогдолтой юм.